

**Орчин цагийн монгол хэлний туслах үйл үгийн
үндэслэл, ач холбогдол**

Сон Бён Гү*

1. Оршил Энэхүү өгүүллийн гол зорилго нь юун түрүүн монгол хэлний туслах үйл үгийг онцлон тодруулж туслах үйл үгийн жирийн үйл үгээс ялгарах гол онцлог хийгээд үндэслэлийг судалгаанд тулгуурлан тодруулахад оршино.

Хэл шинжлэлд туслах үйл үг нь жирийн үйл үгтэй ерөнхийдөө төстэй боловч өөрийн гэсэн онцлог шинжийг агуулж байдаг учраас энэ салбарын эрдэмтдийн сонирхлыг зүй ёсоор татсаар ирсэн билээ. Ялангуяа үйл үгийн нарийвчилсан судалгааны явцад энэхүү туслах үйл үгийн талаар нэгдсэн нэг ойлголтод хүрэх явдал нь гол асуудал болсоор ирсэн. Түүгээр ч барахгүй одоог хүртэл туслах үйл үгийн талаар нэгдсэн нэг ойлголт хараахан гараагүй байгаа гэж үзэхэд болно. Үүнтэй нэгэн адил монгол хэл шинжлэлд дэх туслах үйл үгийн талаарх судалгаа ч гэсэн нэгдсэн нэг ойлголтонд хүрээгүй байгаа гэж үзэхээр байна. Өнөөг хүртэлх судалгаанаас харвал монгол хэлний туслах үйл үгийн ач холбогдол болон үндэслэлийн талаар нарийвчлан хийсэн судалгаа бараг байхгүй байгаа бөгөөд ихэнхдээ ямар үгүүдийг туслах үйл үг гэж үзэх тухай товчхон дурдаж жагсаалт гаргасан байна. Энэ талаар тухайлан судалсан эрдэмтэн Чингэлтэй¹ нь туслах үйл үгийн үндэслэлийн талаар бараг дурдсангүй харин жагсаалтыг нилээд нарийн гаргасан байна.

Иймээс цаашдын судалгааны хамгийн гол чиглэл бол туслах үйл үг гэж үзэж буй үндэслэлийн талаарх нарийвчилсан судалгаа нэн шаардлагатай байгаа бөгөөд энэхүү үндэслэл дээр тулгуурлан нэгдсэн нэг ойлголтонд хүрэх явдал юм.

2. Монгол хэлний туслах үйл үгийн ач холбогдол

Монгол хэлний туслах үйл үгийн талаар судлаачид харилцан адилгүй байр суурьтай байдаг. Туслах үйл үг бий гэсэн үзлийн хажуугаар огт хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс ч бий. Монгол хэл шинжлэлийн олонх эрдэмтэн туслах үйл үгийг хүлээн зөвшөөрдөг боловч

* Соёмбо дээд сургууль

¹ Чингэлтэй, *Одоо үеийн монгол хэлний зүй*. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, Хөх хот, 1999.

Чой. Лувсанжав² нарын эрдэмтэд монгол хэлний туслах үйл үг нь Энэтхэг-Европын хэлний нөлөөгөөр орж ирсэн гэж үзсэн байна. Тэрээр судалгаандаа “Эдгээр үгийг харахад европын туслах үйл үг шиг байдаг юм. Хэл шинжлэлийн үүднээс үзвэл монгол хэлэнд туслах үйл үг байхгүй” гэж үзжээ. Харин монгол хэлний туслах үйл үгийг илүү өргөн хүрээнд судалъя гэвэл монгол хэлтэй төстэй нэг бүлгийн гадаад хэлтэй харьцуулан судлах нь илүү ач холбогдолтой. Үнэндээ туслах үйл үгийн ач холбогдол нь тухайн хэлнийхээ онцлогоос хамаарч өөр өөр байдаг. Эрдэмтэн Сун Жэ Муг³ хэл шинжээч эрдэмтэн Heine⁴ үзлийг жишээ болгон “Энгийн хэл шинжлэлийн хүрээнд туслах үйл үгийн ач холбогдол гэж байдаггүй.” Гэвч “цаг хугацаа, байдал, баймжийн хэлзүйн категорийг илэрхийлдэг үйл үг” хэлбэрээр ач холбогдол нь илэрч болох юм” гэжээ.

Ерөнхийдөө монгол хэлний туслах үйл үгийн талаар судалгаа хийсэн Поппе⁵, Пагва⁶, Бямбасан⁷, Кулманн⁸ нар нь туслах үйл үг нь урдаа орсон үндсэн үйл үгэндээ хүч нэмэгдүүлэн туслах маягаар ордог гэсэн ойлголтон дээр санал нэгдэж, мөн *copula* буюу холбоц үйл үгийн үүргийг гүйцэтгэдэг “бай-, бол-” зэргийг туслах үйл үг гэж үзэх төдий л судалгаа хийсэн байна. Ер нь туслах үйл үгийг илүү өргөн хүрээнд судлахад зөвхөн дээр өгүүлсэн байдлаар хязгаарлалал учир дутагдалтай. Үндсэн үүргээс гадна түүний өгүүлбэр зүйд гүйцэтгэх үүрэг нь заавал судлагдах ёстой. Иймээс дээр өгүүлсэнчлэн туслах үйл үгийг олон талаас нь судлан үзэж түүний ач холбогдлыг илүү тодруулахыг зорилоо.

Туслах үйл үгийн ач холбогдол:

Туслах үйл үг нь өгүүлбэрт орохдоо үндсэн үйл үгтэйгээ ямагт хамт хэрэглэгдэх бөгөөд дангаар өгүүлэхүүний үүргийг гүйцэтгэж чаддаггүй, байдал болон баймжийн утгыг илэрхийлж үндсэн үйл үгэнд туслах байдлаар хэрэглэгдэнэ.

Өөрөөр хэлбэл туслах үйл үг нь урдаа орсон үндсэн үйл үгэнд өгүүлбэр зүйн болон утга зүйн утгаар туслах үүрэгтэй хэрэглэгдэнэ. Хэдийгээр туслах үйл үг нь өгүүлбэрт хэлзүйн утгыг агуулдаг боловч хэлзүйн бүтээврээс арай өөрөөр үйл үгийн хэлбэр байдал болон онцлог шинжийг бүрэн агуулж өгүүлбэрт орно. Гэхдээ утга зүйн талаасаа байдал болон баймжийн утгыг илэрхийлнэ. Энэхүү туслах үйл үгийн утга зүйн талаар цаашид илүү олон талаас нь нарийвчлан үзэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

3. Туслах үйл үг гэж үзэх үндэслэл

Өнөөг хүртэлх монгол хэлний туслах үйл үгийн судалгаанаас харвал ямар үндэслэлээр туслах үйл үгийг жинхэнэ үйл үгээс ялгаж ойлгож болох тухай тодорхой судалгаа байхгүй байна. Үүнээс үүдэн судлаач болгон туслах үйл үгийг өөр өөрөөр тодорхойлдог. Иймээс энэхүү судалгаандаа туслах үйл үгийн утга зүйн болон өгүүлбэр зүйн онцлогт тулгуурлан түүний айг илүү тодруулахыг хичээлээ.

² Чой. Лувсанжав, *Туслах үйл үгийн тухай*, ОУМЭ-ий III-р их хурал. II-р боть. УБ., 1977.

³ Song Jae-mog, *Auxiliary verb constructions in Kalkha Mongolian*, *Linguistics*, 23, Seoul, 1998.

⁴ Heine, *Auxiliaries: Cognitive forces and grammaticalization*, New York, 1993.

⁵ N. Poppe, *Grammar of written Mongolian*, Wiesbaden, Otto Harrassowitz, 1954.

⁶ Т. Пагва, *Вспомогательные, или служебные глаголы в современном монгольском литературном языке*, УБ, 1961.

⁷ П. Бямбасан, (4. Туслах ба дутмаг үйл үгийн тухай)-*Орчин цагийн монгол хэлний үзүүн байгуулалт*. УБ, 1984??

⁸ Rita Kullmann & D. Tserenpil, *Mongolian Grammar*, Ulaanbaatar, 1996.

Туслах үйл үг орсон өгүүлбэр нь ихэнхдээ хоёр үйл үг холбогдож бий болдог учраас нэг талаар нийлмэл өгүүлэхүүнээс бүтсэн өгүүлбэртэй ижил төстэй байх нь бий. Гэвч туслах үйл үг орсон өгүүлбэр нь үүнээс арай өөр, хэлзүйн онцлог ялгаатай байдаг.

- (1) а. Би солонгосоор захиа бичиж үзсэн.
- б. Би жимс хальсалж идсэн.

Дээрх хоёр жишээг харвал туслах үйл үг ялгарч харагдахгүй байгаа мэт боловч нарийн сайн ажиглавал эхний өгүүлбэр дэх гарсан “үзэх” гэдэг туслах үйл үг нь “ямар нэгэн юм үзэж харсан” гэсэн утга биш, харин өгүүлбэрийн үндсэн үйл үг болох “бичих” гэсэн үгэнд утга нэмэгдүүлэн туслах маягаар хэрэглэгдэж байна. Тэгвэл дараагийн өгүүлбэрт “Би жимс хальсалсан.” “Би жимс идсэн” гэсэн хоёр өгүүлбэр нийлж нийлмэл өгүүбэр болсон байна.

Монгол хэлний туслах үйл үг нь өмнөх үйл үгтэйгээ холбох нөхцөлөөр холбогдож ард нь ордог онцлогтой бөгөөд энэхүү үндсэн болон туслах үйл үгийг холбодог нөхцөл нь *-ж*, *-аид*, *-саар*, *-н* зэрэг байдаг. Мөн монгол хэлний туслах үйл үг нь голдуу байдал болон баймжийн утгыг илэрхийлдэг. Гэвч “-даг байх”-тай хамт цаг хугацааг илэрхийлэх үүднээс туслах үйл үг шаардагдах тохиолдол байдаг. Үүнээс гадна монгол хэлний туслах үйл үг нь хэлбэр, байдлын, болон утгын онцлогтой байдаг боловч энд зөвхөн энгийн үйл үгээс ялгагддаг туслах үйл үгийн онцлогийг л авч үзсэн болно. Мөн цаашлаад үүгээрээ дамжуулан туслах үйл үгийг энгийн нийлмэл өгүүлбэрт зэрэгцэж ордог хоёр үйл үгийн арын үйл үгээс хэрхэн ялгаж болох талаар голлон өгүүлэхийг хичээсэн болно. Мөн үүний дээр туслах үйл үгийн энгийн үйл үгээс ялгарах гол онцлог болон үндэслэлийг харуулахыг зорьсон бөгөөд олон эрдэмтэн судлаачдын гаргасан туслах үйл үгийн талаарх судалгаанд тулгуурлалаа.

3.1 Туслах үйл үгийн эрхшээлт чанар

Өгүүлбэрт туслах үйл үгийн энгийн үйл үгээс ялгарах онцлог нь энгийн үйл үггүйгээр дангаар оршин тогтнож чаддаггүй эрхшээлт чанар юм. Өгүүлбэрт үйл үгийн гол үүрэг нь дүрслэх үүрэг юм. Гэтэл дүрслэх үүрэг гүйцэтгэдэггүй үйл үг байдаг нь үүнийг энгийн үйл үгээс ялгаж ойлгох хэрэгтэйг харуулсан хамгийн гол үндэслэл юм.

Өөрөөр хэлбэл туслах үйл үг нь өгүүлбэрт дангаараа дүрслэн үзүүлэх үүрэг гүйцэтгэж чаддаггүй, ямагт үндсэн үйл үгтэй хамт орж түүнд туслах үүрэг гүйцэтгэдэг гэсэн үг юм.

- (2) а. Би түүнд хэлж орхисон.
- б. Би түүнд хэлсэн.
- в. * Би түүнд орхисон.

Дээрх жишээнээс эхний өгүүлбэрт “орхих” гэсэн үг нь өмнөх үндсэн үйл үг “хэлэх” гэсэн үгтэй хамт хэрэглэгдсэн бол 2 дахь өгүүлбэр нь ямар нэгэн утга илэрхийлж, 3 дахь өгүүлбэр нь огт утгагүй болж байна. Үүнээс харахад туслах үйл үг нь дангаар өгүүлбэрт орж үүрэг гүйцэтгэж чадахгүй, үндсэн үйл үгийн эрхшээлд байдгаараа онцлогтой юм.

3.2 Хэлзүйн утгат чанар

Туслах үйл үгийг үндсэн үйл үгээс ялгарах хоёр дахь онцлог нь хэлзүйн утгат чанар юм.

- (3) а. Би найзаасаа асууж үзлээ.

б. Би кино үзлээ.

Дээрх хоёр жишээнд “үзэх” гэсэн ижил утгатай дүрслэх үйл үг байгаа боловч утгат талаас нь авч үзвэл огт өөр утга гарч ирнэ. Хоёр дахь өгүүлбэрт “үзэх” гэсэн үгийн жинхэнэ утга нь хэвээр хадгалагдаж байгаа боловч эхний өгүүлбэрт гарч буй “үзэх” гэсэн үг нь “асуух” гэсэн үндсэн үйл үгийн утгад “оролдлого хийх” гэсэн хэлзүйн утгыг нэмж өгч байна. Өөрөөр хэлбэл, монгол хэлний туслах үйл үгийн үндсэн утга биш, хэлзүйн утгыг агуулж байгаагаараа онцлог юм.

3.3 Орлуулан хэрэглэж болдоггүй чанар

Туслах үйл үгийн гурав дахь онцлог нь өөр үгээр орлуулж болдоггүй чанар юм. Үүнийг доорх жишээнээс харж болно.

- (4) а. Би гэдэс өлссөнөөс идэж орхисон.
 б. Би гэдэс өлссөнөөс тэгж орхисон.
 в. * Би гэдэс өлссөнөөс идэж тэгсэн.

Дээрх жишээний эхний хоёр өгүүлбэрт “идэх” гэсэн үндсэн үйл үгийг “тэгэх” гэсэн өөр үгээр орлуулан хэрэглэхэд үндсэн утга нь алдагдахгүй байна. Харин гурав дахь өгүүлбэрийн “орхих” гэсэн туслах үйл үгийг орлуулан хэрэглэхэд огт утгагүй болж байна. Үүнээс харахад монгол хэлний туслах үйл үг нь орлуулан хэрэглэх боломжгүй байна.

3.4 Туслах болон үндсэн үйл үгийг салгаж болдоггүй

Туслах болон үндсэн үйл үгийн завсарт өөр үг оруулах зэргээр хооронд нь салгаж болдоггүй.

- (5) а. Чи энэ усыг уугаад үз.
 б. Чи энэ усыг хурдан уугаад үз
 в. *Чи энэ усыг уугаад хурдан үз.

Дээрх жишээний эхний өгүүлбэрт үндсэн үйл үг болох “уух”, туслах үйл үг болох “үзэх” хоёр холбогдон орж байна. Хоёр дахь өгүүлбэрт “туслах” гэсэн дайвар үг үндсэн үйл үгийн өмнө орсноор утга хадгалагдаж байна. Харин гурав дахь өгүүлбэрт туслах болон үндсэн үйл үгийн хооронд “хурдан” гэсэн дайвар үг орж ирэхэд өгүүлбэрийн утга алдагдсан байна. Үүнээс харахад энэ хоёр үйл үг нь салах боломжгүй нягт холбоотой байдгаараа онцлог юм.

3.5 Туслах болон үндсэн үйл үгийн байрыг сольж болдоггүй

Туслах үйл үг орсон өгүүлбэрт үндсэн үйл үг болон туслах үйл үгийн байрыг сольж болдоггүй. Харин нийлмэл өгүүлэхүүн орсон өгүүлбэрт хоёр үйл үгийн байрыг сольж болно. Жишээ нь:

- (6) а. Би бууз идэж үзсэн.
 б. Би идэж үзсэн, бууз
 в. * Би бууз үзсэн, идэж
- (7) а. Би өндөг шарж идсэн
 б. Би шарж идсэн, өндөг

в. Би өндөг идсэн, шарж

Дээрх жишээнээс харвал 6- нь “үзэх” гэдэг туслах үйл үг орсон өгүүлбэр юм. ба- нь үндсэн үйл үг болон туслах үйл үгийг салгахгүйгээр тусагдахууныг өгүүлбэрийн ард оруулахад утга алдагдахгүй байна. Харин бв-д орсон үндсэн үйл үг болох “идэх” ба туслах үйл үг болох “үзэх” гэсэн хоёр үгийн байрыг солиход өгүүлбэрийн утга алдагдаж байна. Ингэж туслах үйл үг нь байдал болон баймжийн утга илэрхийлдэг учраас ямагт өгүүлбэрийн хойно байрладаг онцлогтой. Иймээс туслах үйл үг нь үндсэн үйл үгийн өмнө орох боломжгүй юм.

Дараагийн 7-д өгүүлсэн жишээнд “шарах”, “идэх” гэсэн хоёр үйл үг нэг үүрэгтэйгээр орсон нийлмэл өгүүлэхүүнтэй өгүүлбэр юм. 7а-д хоёр үйл үгийг салгахгүйгээр тусагдахууны байрыг сольж хойно оруулсан. Мөн 7в-д хоёр үйл үгийн байрыг сольсон. Энэхүү жишээнээс харвал нийлмэл үйл үг орсон өгүүлбэр нь гишүүдийн байрыг сольж болдгоороо туслах үйл үгтэй өгүүлбэрээс ялгаатай.

3.6 Товчилж болдог чанар

Жирийн өгүүлбэрт түүний утгыг алдагдуулахгүйгээр зарим гишүүдийг хасаж товчилж болдог. Иймээс туслах үйл үг орсон өгүүлбэрийн туслах ба үндсэн үйл үг, бас туслах үйл үгийг дангаар нь хасаж товчилж болдог. Харин үндсэн үйл үгийг хасаж болдоггүй.

- (8) а. Ах нь ном уншиж байна. Дүү нь сонин уншиж байна.
 б. Ах нь ном, дүү нь сонин уншиж байна.
 в. Ах нь ном уншиж, дүү нь сонин уншиж байна.
 г. *Ах нь ном байна. Дүү нь сонин уншиж байна.

Дээрх 8а-д “байх” гэдэг туслах үйл үг орсон хоёр өгүүлбэр байна. 8б-д туслах болон үндсэн үйл үг, 8в-д “байх” гэсэн туслах үйл үг нь товчлогдсон байна. Харин 8г-д унших гэсэн үндсэн үйл үг товчлогдсоноор өгүүлбэрийн утга алдагдсан байна.

4. Дүгнэлт

Монгол хэлний туслах үйл үгийн ач холбогдол болон үндэслэлийг дэлгэрүүлэн

- туслах үйл үгийн эрхшээлт чанар
- хэлзүйн утгат чанар
- орлуулан хэрэглэж болдоггүй чанар
- туслах болон үндсэн үйл үгийг салгаж болдоггүй чанар
- туслах болон үндсэн үйл үг-ийн байрыг сольж болдоггүй чанар
- товчилж болдог чанар гэж зургаа хуваан үзлээ.

Цаашид ч бас илүү дэлгэрүүлэн судалж монгол хэлний туслах үйл үгийн онцлог хийгээд үндэслэлийг илүү нарийвчлан судлах шаардлагатай байна гэж үзэж байна.

Туслах үйл үгийн үндэслэлийг судалж тогтоох явдал нь орчин цагийн монгол хэл судлаач эрдэмтдийн туслах үйл үг гэж үзсэн үгнүүдийг дахин нэг нягтлан үзэх шалгуур болох бөгөөд энэхүү судалгаан дээрээ тулгуурлан илүү нарийвчилсан судалгаа хийх боломж олдох юм.

Ашигласан ном зохиол

- N.Poppe/1954/ Grammar of Written Mongolian, Wiesbaden, Otto Harrassowitz
- Т.Парба /1961/ Вспомогательные, или служебные глаголы в современном монгольском литературном языке, УБ
- John C.Street/1963/ Khalkha structure, Uralic and Altaic Series 24, Bloomington.
- James Bosson/1964/ Modern Mongolian: A primer and a reader, Uralic and Altaic Series 38, Bloomington.
- P.Aalto /1973/ Auxiliary verbs in Mongolian, ОУМЭ-ий II их хурал, I боть, УБ.
- Чой. Лувсанжав /1977/ Туслах үйл үгийн тухай. ОУМЭ-ий III-р их хурал. II-р боть. УБ.
- П.Бямбасан /1984/ (4.Туслах ба дутмаг үйл үгийн тухай)-Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулалт. УБ.
- Heine/1993/ Auxiliaries: Cognitive forces and grammaticalization. New York
- Rita Kullmann & D. Tserenpil /1996/ Mongolia Grammar, Ulaanbaatar.
- Song Jae-mog/1998/ Auxiliary verb constructions in Kalkha Mongolian, Linguistics 23, Seoul.
- Kwon Jae-il/1998/ Auxiliary verb construction in Korean and Khalkha Mongolian, The third international symposium on Mongology, Summaries of symposiums, Hohhot.
- Чингэлтэй/1999/ Одоо үеийн монгол хэлний зүй, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, Хөх хот.
- Kang shin/2003/ On the Auxiliary verb in modern Mongolia, Journal of Mongolian Studies, 15, Seoul.
- 호광수/2003/ 국어 보조용언 구성 연구. 서울
- Anderson, Gregory D.S./2006/ Auxiliary verb constructions. New York.

Abstract

**The Basics and Significance of Auxiliary Verbs
in Modern Mongolian**

In this article the author deals with the basic notion and significance of auxiliary verbs in Modern Mongolian in more details. A special study on what should be the causes for auxiliaries to be called so is been actually absent among previous researchers. Since the detailed observation on their peculiarities and significance are in lack a special attention was paid to this aspect and they were considered in six ways. There should be some more peculiarities apart from these six. In this case they are supposed to be specified in the future researches, as the author claims. The researches should present more interest if it is conducted in comparison of the Mongolian language with the other relative languages of the same group.